**БАЯНТАЛ СУМЫН 2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН**
**ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

2025.03.25 Баянтал сум

## Нэг. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Сумын удирдах ажилтны шуурхай хурлыг 2 удаа, Засаг даргын зөвлөлийн хуралдаан 1 удаа, дотоод хурлыг 7 хоног болгоны 1 дэх өдөр хуралдаж үүрэг даалгаварыг сумын Засаг дарга болон, ЗДТГ-н дарга нараас өгсөн төрлийн үүрэг даалгаврыг тухай бүр хариуцсан албан хаагчдад дамжуулан өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

**Цахим мэдээлэл:** "Говьсүмбэр аймгийн Баянтал сум" фэйсбүүк групп хуудсанд нийт 32 мэдээлэл оруулсан үүний 10 ведио, 22 зурган мэдээлэл байна. Аймгийн хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол шэйр хийж түгээж ажилласан байна.

Мөн Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг шейрлэж ажилласан. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 07/742 дугаар үүргийн биелэлтийг ханган 2 цаг тутам аймгийн Онцгой штабт цаг үеийн мэдээлэл өгч байна. Байгууллагын ажилтнууд 24 цагаар жижүүрлэн ажиллаж байна.

## НЭГ. ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

**Шилэн данс:** Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 10 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 03 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 90 хувьтай байна.

3 дугаар сарын орлого:

1. Говьсүмбэр, Баянтал Суутган 15,278,849.45
2. Говьсүмбэр, Баянтал Улсын тэмдэгтийн хураамж- 3300.00
3. Говьсүмбэр, Баянтал Газрын төлбөр 19,306,833.00
4. Говьсүмбэр, Баянтал **Ба Хувь хүний ОАТ** 30,000.00
5. Говьсүмбэр, Баянтал малын тоо толгой албан татвар 275,500.00
6. Говьсүмбэр, Баянтал иргэн ҮХХБАТ 75,480.00
7. Говьсүмбэр, Баянтал Ба Хог хаягдлын хураамж 18000.00

Нийт: 34,987,962.45

2025 оны 03 дугаар сарын 26-ны байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөө 39,270.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэл 121,229.2 мянган төгрөгөөр буюу 323,9%-иар орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

## ХОЁР. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Энэ хавар нийт 66 малчны 43717 толгой мал хаваржихаас нутагтаа 35567, Төв, Дундговь аймгууд, Сүмбэр 6-р багийн  нутгуудад 16 өрхийн 8150 толгой мал отроор хаваржиж байна.

Нийт 24436 эх мал төллөхөөс 328 мал төллөж мал төллөлт 0.02 %, 328 толгой төл хүлээн авч төл бойжилт 100 %-тай байна.

Хүчтэй шороон шуурга ойр ойрхон шуурч байна. 2025.03.11-нд хүчтэй шороон шуурга, 2025.03.24-нд цасан шуурга шуурсан боловч ноцтой хүндрэл гараагүй. Лүн, Их уул багийн дарга нар малчдаас утсаар мэдээлэл авч ажилласан.

Аймгаас малчдад тусламжаар ирүүлсэн 25 тн тэжээлийн будааг агуулахад байршуулж малчдад тус бүр 3 шуудайг олгож байна.

## ГУРАВ. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Байгаль орчны чиглэлээр:**

2025.02.27-ны өдөр Баянтал сумын 4-р сургуулийн 5-9-р ангийн 43 хүүхдэд хог хаягдал гэж юу вэ?, хог хаягдлын ангилал, түүнийг дахин боловсруулах арга сэдвээр сургалт орж мэдлэг ойлголтыг дээшлүүлж байгаль орчны талаар мэдлэг олгосон.

Цагаан сарын баярыг тохиолдуулан орчноо бохирдуулахгүй, хогоо хогын саванд хийх, цэвэр цэмцгэр байцгаая уриан дор 4-р сургуулийн сурагчтайгаа хамтран видео бичлэг эвлүүлэн Баянтал сумын пэйж хуудсандаа байршуулан ажиллаж 43 хүний хандалттай байна.







**ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Бүсгүй минь чи инээмсэглэж яваарай” караоке тэмцээнийг зохион байгууллаа. Уралдаанд нийт 5 баг оролцов.

Мөн Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн Г.Бандицэрэн /Чила/ урьж сумын Ерөнхий боловсролын сурагчид нийт 85, Төрийн албан хаагчид 80, сумын иргэдэд 120 нийт 285 иргэнд “Амьдралын үнэ цэнэ, утга учир” сэдвээр лекц тавилаа.






БАЯНТАЛ СУМ

**БАЯНТАЛ СУМЫН 2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН**
**ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

2025.01.24 Баянтал сум

## Нэг. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Сумын удирдах ажилтны шуурхай хурлыг 2 удаа, Засаг даргын зөвлөлийн хуралдаан 1 удаа, дотоод хурлыг 7 хоног болгоны 1 өдөр хуралдаж үүрэг даалгаварыг сумын Засаг дарга болон, ЗДТГ-н дарга нараас өгсөн төрлийн үүрэг даалгаврыг тухай бүр хариуцсан албан хаагчдад дамжуулан өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

**Цахим мэдээлэл: "**Говьсүмбэр аймгийн Баянтал сум" фэйсбүүк групп хуудсанд нийт 35 мэдээлэл оруулсан үүний 12 ведио, 23 зурган мэдээлэл байна. Аймгийн хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол шэйр хийж түгээж ажилласан байна.

Мөн Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 3 шейрлэж ажилласан.

Төрийн үйлчилгээний ХУРДАН цэгээс https://operator.e-mongolia.mn/dashboard системээр 12 сарын 25 наас 01 сарын 24-ны хүртэл нийт 12 төрлийн 77 лавлагаа мэдээлэл гаргаж ажилласан. Үүнээс:

- Иргэний үнэмлэхийн лавлагаа – 19
- Оршин суугаа хаягын тодорхойлолт - 11
- Гэрлэсний бүртгэлийн лавлагаа – 6
- Мал тооллогын лавлагаа – 4
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт -1
- Зээлийн мэдээллийн лавлагаа – 2
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа – 12
- Эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах – 3
- Төрсний бүртгэлийн лавлагаа – 1
- Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тухай лавлагаа -8
- Гэрлэсний бүртгэлгүй лавлагаа – 4
- Малчны тодорхойлолт -6

## Хоёр. ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

**Шилэн данс:** Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 10 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 01 дүгээр сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 85 хувьтай байна.

12 дугаар сарын орлого:

1. Говьсүмбэр, Баянтал Суутган 5,029,237.46
2. Говьсүмбэр, Баянтал Хувь хүний АТ- 43,500.00
3. Говьсүмбэр, Баянтал Газрын төлбөр 42,196.00
4. Говьсүмбэр, Баянтал ҮХЭХАТ- 1,407,840.00
5. Говьсүмбэр, Баянтал Улсын тэмдэгтийн хураамж 285,250.00
6. Говьсүмбэр, Баянтал малын тоо толгой албан татвар 520,000.00
7. Говьсүмбэр, Баянтал иргэн ҮХХБАТ 169,200.00
8. Говьсүмбэр, Баянтал Хадгаламжийн хүү орлого 458,292.05
9. Говьсүмбэр, Баянтал Галт зэвсэг 30,000.00
10. Гс.Ба Хог хаягдлын хураамж 50,000.00

Нийт: 8,035,515.51

## Дөрөв. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

2024 оны Аюулгүй нөөцөнд 1475 боодол өвс, 500 боодол ногоон тэжээл татан авч хураах ажилласан.

Жилийн эцсийн мал тооллогыг 2024 оны 12 сарын 07-ны өдрийн тоот захирамжаар ажлын хэсэг гаргаж ажилласан.

**Мал эмнэлэг:** Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 68 өрхийн 2139 үхэр, Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуултанд 62 өрхийн 15190 хонь, хурга, мөн 8 сарын 15-нөөс эхлэн угаалгын явцад 20 гаран өрх хамрагдсан. 10 сард бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 37 өрхийн хонь 70783, ямаа 850, нийт 71633 толгой мал хамрагдсан байна.

**Хөдөлмөр, Халамж үйлчилгээний чиглэлээр**:

Сумын "Амьжиргаа дэмжих зөвлөл" 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хуралдав. Хуралдаанаар:
Байнгын асаргаанд шинээр орох 2 иргэн, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоох 1 иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

## ТАВ. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Байгаль орчны чиглэлээр:**

1. Нийтийн их цэвэрлэгээг 2025.01.16-нд зарлаж албан байгууллага, аж ахуйн нэгж болон сумын ард иргэд нийт 78 хүн гарч 2.60 тонн хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн хаясан.

 

2. Байгаль орчны газраас ирсэн хугацаатай бичгийн хариуг хүргүүлж, Аймгийн мэргэжилтэнтэй хамт мод тарих газар болон 5 худгийн байршлийг тодорхойлох чиглэлээр хамтран ажиллав.

БАЯНТАЛ СУМ

**БАЯНТАЛ СУМЫН 2025 ОНЫ 02 ДУГААР САРЫН**
**ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

2025.02.25 Баянтал сум

## Нэг. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Сумын удирдах ажилтны шуурхай хурлыг 2 удаа, Засаг даргын зөвлөлийн хуралдаан 1 удаа, дотоод хурлыг 7 хоног болгоны 1 өдөр хуралдаж үүрэг даалгаварыг сумын Засаг дарга болон, ЗДТГ-н дарга нараас өгсөн төрлийн үүрэг даалгаврыг тухай бүр хариуцсан албан хаагчдад дамжуулан өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

**Цахим мэдээлэл:** "Говьсүмбэр аймгийн Баянтал сум" фэйсбүүк грүпп хуудсанд нийт 30 мэдээлэл оруулсан үүний 10 ведио, 20 зурган мэдээлэл байна. Аймгийн хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол шэйр хийж түгээж ажилласан байна.

Мөн Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг шейрлэж ажилласан.

Төрийн үйлчилгээний ХУРДАН цэгээс https://operator.e-mongolia.mn/dashboard системээр 01 сарын 25 наас 02 сарын 24-ний хүртэл нийт 7 төрлийн 25 лавлагаа мэдээлэл гаргаж ажилласан. Үүнээс:

- Иргэний үнэмлэхийн лавлагаа – 10
- Оршин суугаа хаягын тодорхойлолт - 5
- Гэрлэсний бүртгэлийн лавлагаа – 3
- Зээлийн мэдээллийн лавлагаа – 3
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа – 2
- Эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах – 1
- Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тухай лавлагаа -1

## Хоёр. ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

**Шилэн данс:** Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 10 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 02 дүгээр сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 80 хувьтай байна.

2 дугаар сарын орлого:

1. Говьсүмбэр, Баянтал Суутган 35,929,934.10
2. Говьсүмбэр, Баянтал Улсын тэмдэгтийн хураамж- 24,200.00
3. Говьсүмбэр, Баянтал Газрын төлбөр 16,594,396.00
4. Говьсүмбэр, Баянтал ҮХЭХАТ- 7124.00
5. Говьсүмбэр, Баянтал малын тоо толгой албан татвар 507,500.00
6. Говьсүмбэр, Баянтал иргэн ҮХХБАТ 2,820,000.00

7. Говьсүмбэр, Баянтал Хадгаламжийн хүү орлого 368,988.92
8. Гс.Ба Хог хаягдлын хураамж 750,000.00

Нийт: 57,002,143.02

## Гурав. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Энэ өвөл сумын хэмжээнд 66 малчны 43606 толгой мал өвөлжихөөс нутагтаа 35456, Төв, Дундговь аймгууд, Сүмбэр 6-р багийн нутгуудад 16 өрхийн 8150 толгой мал отроор өвөлжиж байна.

Хүчтэй цасан ба шороон шуурга ойр ойрхон шуурч байна.

Аймгаас малчдад тусламжаар ирүүлсэн 25 тн тэжээлийн будааг агуулахад байршуулсан.

## Дөрөв. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

**Байгаль орчны чиглэлээр:**

1. Нийтийн их цэвэрлэгээг 2025.02.17-нд зарлаж албан байгууллага, аж ахуйн нэгж болон сумын ард иргэд нийт 78 хүн гарч 2.60 тонн хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн хаясан.





2025 оны 02 дугаар сарын 24-нд Булган аймгийн Хишиг өндөр сумын хог хаягдал зохицуулах төв дээр сумын Засаг дарга, ИТХ-ын даргын хамт туршлага судалж ирсэн.





2025 оны 02 дугаар сарын 25-нд Сургуулийн зүүн талын хогийн савны хогийг ачиж, хаалгатай болгосон. Нийт 800 тонн хог хаягдал төвлөрсөн хогийн цэгт зөөвөрлөн хаясан.

## БАЯНТАЛ СУМ